Багш нарын цахим сургалтын талаарх сэтгэл ханамж

Б.Балжинням[1], С.Гал-Эрдэнэ[1], М.Үзмээ[1], Г.Нарансүх[1], С.Хандмаа[1]
[1]АШУҮИС-ийн Багший хөгжил, цахим сургалтын газар
baljinnyam@mnums.edu.mn

Түлхүүр үг
Цахим сургалт, багш, сэтгэл ханамж, онлайн сургалт

Товч утга
КОВИД-19 халдварын улмаас сургалтыг цахимаар явуулж буй энэ үед багш нар хичээлээ хэрхэн зохион байгуулж буй болон тэдний цахим сургалтын талаарх сэтгэл ханамжийг тодорхойлох шаардлагатай. Судалгаанд 342 багш хамруулан мэдээллийг асуумжийн аргаар цуглуулж, одоогийн нөхцөл, цаашдын боломж болон сэтгэл ханамж зэргийг тодорхойлж, үр дүнг тооцсон. Багш нарын ихэвчлэн онлайнаар нүүр нүүрээ харах болон вебд суурилсан аргуудыг хослуулан хичээлийг зохион байгуулсан байна. Багш нараас цаг хугацаа их шаарддаг, оюутнуудын оролцоо думтаг, гардан үйлдлийн ур чадвар эзэмшүүлэхэд дутагдалтай, харин орон зайнаас үл хамааран давуу тал болж байна гэж үзсэн. Цаашид танхим болон онлайн сургалтыг хослуулж, лекц, бие даалтыг ихэвчлэн цахим хэлбэрээр зохион байгуулах нь тохиромжтой, ингэхийн тулд багш нарт технологийн дэмжлэг хэрэгтэй байна. Багш нарын өөрсдийн цахим сургалтын талаарх мэдлэг, орчин нөхцөл, цахим сургалтыг танхимын сургалттай харьцуулсан байдал, багш нарын суралцагчидтай тогтоосон эргэх холбоо, үнэлгээний бодитой байдал, сургалтын систем зэрэгт сэтгэл ханамжийн түвшин дундаж болон түүнээс дээш байсан. Сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулахад дутагдалтай талууд байгаа боловч, цахим сургалтад багш нар сэтгэл ханамжтай, цаашид хосолсон сургалт хэрэглээ нэмэгдэхээр байна.

Үндэслэл

Дээд боловсролын салбарт цахим сургалт эрчимтэй хөгжиж, их дээд сургуулиуд цахим сургалтын нөхцөлөө сайжруулж, цахим хэлбэрээр суралцах оюутны тоо нэмэгдсээр байна. Цахим сургалт гэдэг нь заах болон сурах үйл явцад мэдээллийн технологи ашиглаж буй хэлбэр гэж тодорхойлсон байдаг. КОВИД-19 халдвар гарч, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас цар тахлын шинжтэй хэмээн зарлаж, улс орнуудад хөл хорио тогтоосноор боловсролын байгууллагын сургалт танхимд явагдах боломжгүй болж, цар тахлын оргил үед дэлхий даяар суралцагчдын 91.3 хувь нь сургуульд явах боломжгүй, зайнаас сургалтаа үргэлжлүүлж, богино хугацаанд олон сая багш нар компьютерийн дэлгэцийн өмнө хичээл зааж эхэлсэн бөгөөд суралцагчид нь гэрээсээ интернетээр дамжуулан төрөл бүрийн технологийг ашиглан суралцах шаардлагатай болсон. Харин Монгол Улсад 2020 оны 1 дүгээр сарын 27-оос 2021 оны 4 дүгээр сар хүртэл хугацаанд нийт 34 долоо хоногийн турш сургалтыг зайн сургалтын хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд дээд боловсролын үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд өөрсдийн нөөц боломжид суурилан цахим хэлбэрээр сургалтын үйл ажиллагааг үргэлжүүлж байна. КОВИД-19 халдварын улмаас цахим сургалтад шилжсэн энэ үед цахим сургалтын талаарх багш нарын үнэлэмж, сэтгэл ханамжийг судалснаар цаашид сайжруулах хэрэгцээ, арга замыг тодорхойлоход ач холбогдолтой юм.

Зорилго, зорилт

Цахим сургалтын хэрэгжилт, нөхцөл, боломжийг судлах, багш нарын сэтгэл ханамжийг тодорхойлох

1. Цахим хэлбэрээр багш нар хичээлээ хэрхэн зохион байгуулж буйг тодорхойлох
2. Цахим сургалтын талаарх багш нарын сэтгэл ханамжийг үнэлэх
3. Цаашид хэрхэн цахим сургалтыг хэрэгжүүлэх, сургалтад ашиглах талаар судлах

Арга аргачлал

Судалгааг нэг агшны дескриптив загварыг ашиглан хийж гүйцэтгэсэн. Судалгааны хэрэглэгдэхүүний хувьд нээлттэй болон хаалттай 35 асуулт бүхий асуумжийг ашиглан, АШУҮИС-ийн 604 багшид онлайн хэлбэрээр цахим шуудан ашиглан 2021 оны 3 дугаар сард илгээсэн бөгөөд 7 хоногийн хугацаанд 342 багш хариулсан нь нийт багш нарын 56.2 хамрагдсан байна. Сэтгэл ханамжийг түвшинг огт сэтгэл ханамжгүйгээс маш их сэтгэл ханамжтай хүртэл 1-5 оноогоор үнэлж, дундаж үзүүлэлтийг тооцсон. Судалгааны мэдээллийг нэгтгэхдээ MS Excel 2016 программ, үр дүнг тооцохдоо SPSS 21 программ, зураг дүрслэлийг MS Word 2016, Graphpad Prism программуудыг ашиглав.


Үр дүн

Судалгаанд нийт 342 багш хамрагдсан ба багш нарын 73.1% нь эмэгтэй, 26.9% нь эрэгтэй байв. Тэнхмийн харъяалалын хувьд онолын болон эмнэлзүйн тэнхмийн жигд хамрагдсан.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан багш нарын ерөнхий мэдээлэл


	Хүйс				Нийт	
	Эмэгтэй		Эрэгтэй			
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Нас						
30-с доош	16	55.2%	13	44.8%	29	8.5%
31-40 нас	95	66.4%	48	33.6%	143	41.8%
41-50 нас	83	85.6%	14	14.4%	97	28.4%
51-60 нас	55	80.9%	13	19.1%	68	19.9%
61-с дээш	1	20.0%	4	80.0%	5	1.5%
Ажилласан жил						
5-с доош	60	75.0%	20	25.0%	80	23.4%
6-10 жил	57	61.3%	36	38.7%	93	27.2%
11-15 жил	52	73.2%	19	26.8%	71	20.8%
16-20 жил	41	93.2%	3	6.8%	44	12.9%
21-25 жил	21	84.0%	4	16.0%	25	7.3%
26-с дээш	19	65.5%	10	34.5%	29	8.5%
Эрдмийн зэрэг, цол						
Профессор	11	55.0%	9	45.0%	20	5.8%
Дэд профессор	30	73.2%	11	26.8%	41	12.0%
Доктор	57	74.0%	20	26.0%	77	22.5%
Магистр	152	74.5%	52	25.5%	204	59.6%
Албан тушаал						
Профессор	11	50.0%	11	50.0%	22	6.4%
Дэд профессор	23	79.3%	6	20.7%	29	8.5%
Ахлах багш	74	81.3%	17	18.7%	91	26.6%
Багш	93	66.0%	48	34.0%	141	41.2%
Дадлагажигч багш	44	83.0%	9	17.0%	53	15.5%
Гэрээт багш	5	83.3%	1	16.7%	6	1.8%

Хичээлийг багш нар ихэвчлэн шууд онлайнаар холбогдох болон веб хослуулан зохион байгуулсан гэж 57.9%, шалгалтаа гүүглийн боловсролын багцийн аппликэйшнүүдийг ашиглан зохион байгуулсан гэж 83.3%, 2020-2021 оны хичээлийн жилд лекцийн материалаа шинэчилсэн гэж 79.8%, цахим хичээлийн удирдамж, гарын авлага боловсруулсан гэж 69.9%, вебд суурилсан материалыг аудио, видео хэлбэрээр зохион байгуулах нь тохиромжтой байсан гэж 87.4%хариулсан байна.




Зураг 1. Цахим сургалтын үеийн хичээлийн зохион байгуулалт

Багш нар цахим хэлбэрээр хичээлийг зохион байгуулахад хугацаа их шаарддаж байгаа нь бидэнд хүндрэлтэй (57.9%) байна гэсэн бол суралцах орчин нөхцөл дутмаг байдал нь оюутнуудад хүндрэлтэй (84.2%) гэж үзсэн.



Зураг 2. Цахим сургалтын сул болон давуу талууд

Мөн гар үйлдлийн ур чадварыг эзэмшүүлэхэд дутагдалтай гэж 74% нь үзсэн бол интернет болон техникийн асуудал огт тулгараагүй гэж 31.4%, заримдаа тулгарч байсан гэж 63.3% нь хариулсан байна. Нөгөө талаас орон зайнаас үл хамаарсан, хичээлээ гэрээсээ удирдан зохион байгуулах нь олон боломжийг нэмэгдүүлж байна (89.2%) гэж хариулсан.



Зураг 3. Цахим сургалтын тохиромжтой арга, хэлбэр, шаардлагатай дэмжлэг


Танхим болон цахим хосолсон арга тохиромжтой гэж 56.4%, хичээлийн хэлбэрүүдээс лекц, бие даалтыг зохион байгуулах нь тохиромжтой гэж ихэнх хувь нь үзсэн бол сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулахад багш нарт технологийн дэмжлэг хэрэгцээтэй гэж 73.1 хувь хариулсан байна.

Хүснэгт 2. Цахим сургалтын талаар багш нарын сэтгэл ханамжийн түвшин

	Онол		Эмнэл зүй		Нийт	
	Mean	SD	Mean	SD	Mean	SD
Цахим сургалтын талаарх мэдлэг	3.92	0.64	3.92	0.54	3.92	0.59
Орчин нөхцөлөөр хангагдсан*	3.18	0.83	3.40	0.81	3.29	0.82
Танхимын сургалттай харьцуулсан үнэлгээ	3.41	0.71	3.29	0.71	3.35	0.71
Суралцагчидтай тогтоосон эргэх холбоо	3.76	0.73	3.82	0.75	3.79	0.74
Үнэлгээний бодитой байдал	3.18	0.76	3.24	0.65	3.21	0.71
Цахим сургалтын систем	3.66	0.75	3.73	0.75	3.70	0.75
Ерөнхий үнэлгээ	3.50	0.63	3.52	0.68	3.51	0.65

*p<0.05

Цахим сургалтын талаарх багш нарийн ерөнхий сэтгэл ханамжийн түвшин 3.51±0.65 байв. Зарим үзүүлэлтээр багш нарын сэтгэл ханамжийн түвшинг тооцоход цахим сургалтын талаарх өөрийн мэдлэг 3.92±0.59, орчин нөхцөлийн хангалт 3.29±0.82, танхимын сургалттай харьцуулалт 3.35±0.71, суралцагчидтай тогтоож буй эргэх холбоо 3.79±0.74, үнэлгээ 3.21±0.71, цахим сургалтын систем 3.7±0.75 байна.



Зураг 4. Багш нарын цахим сургалтад өгсөн үнэлгээний ялгаатай байдал

Багш нар өөрсдийн цахим сургалтын талаарх мэдлэг, суралцагчидтай тогтоосон эргэх холбоо, цахим сургалтын систем зэрэгт харьцангуй өндөр үнэлгээ өгсөн бол орчин, нөхцөл, танхимын сургалттай харьцуулсан байдал, үнэлгээний бодитой байдал зэрэгт бусад үзүүлэлттэй харьцуулахад бага байна. Эрдмийн сургууль, Анагаах ухааны сургуулийн багш нар харьцангуй өндөр үнэлгээ өгсөн байна.

Хэлцэмж

Энэхүү судалгаагаар цар тахлын үед хичээлийг онлайн хэлбэрээр зохион байгуулсан анагаахын их, дээд сургуулийн багш нарыг хамруулан одоогийн нөхцөл, цаашдын боломж , сэтгэл ханамж зэргийг судалж үзсэн болно. Судалгааны үр дүнд цахим сургалтын үед багш нарын зарцуулах хугацаа их, оюутнуудын орчин, нөхцөл харилцан адилгүй зэрэг бэрхшээлүүд тулгарч байгаа боловч орон зайнаас үл хамааран сургалтын ихэвчлэн гэрээсээ онлайн шууд холболт болон веб хослуулан зохион байгуулж, багш нар цахим сургалтад өгсөн үнэлгээ дунджаас дээгүүр, цаашид сургалтанд хосолсон сургалтын хэлбэр нэмэгдэхээр байна. Интернет, гар утас, компьютер зэргээс хамаарсан хүртээмжийн тодорхойлсон судалгаанууд өмнө нь хийгдэж байсан. Тухайлбал, Мюиленберг ба Берге нар (2005) интернетэд нэвтрэх зардал, интернетэд нэвтрэх боломжийг тийм ч чухал биш саад тотгор гэж үзсэн. Мөн Сан-Мартин, Жименес нарын (2020) судалгаагаар багш нарын онлайн хэлбэрээр хичээлийг удирдахад цахим сургалтын системийн чанар болон зохион байгуулалтын дэмжлэг хэрэгтэй байгааг тодорхойлсон нь бидний судалгааны үр дүнтэй нийцэж байна. Судлаачид цахим сургалтын талаарх багш нарын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд ямар хүчин зүйл нөлөөллийг цаашид судлах хэрэгцээ байгааг дурдсан байна.

Дүгнэлт

Сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулахад дутагдалтай талууд байгаа боловч, цахим сургалтыг төрөл бүрийн арга хэлбэрүүдийг ашиглан орон зайнаас үл хамааран зохион байгуулж байна. Цахим хэлбэрээр хүргэхэд лекц болон бие даалтын хэлбэрийг хамгийн тохиромжтой, багш нарт технологийн дэмжлэгийг нэмэгдүүлэхэд хосолсон сургалт хэрэглээ нэмэгдэхээр байна. Цахим сургалтад өгсөн багш нарын сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ дунджаас дээгүүр боловч зарим үзүүлэлтэд сургуулиас хамааран хангалтгүй гэж үнэлсэн байна.

Ном зүй

1. *Teo T. Preservice teachers' satisfaction with e-learning. Social Behavior and Personality: an international journal. 2014 Feb 15;42(1):3-6.*
2. *Almaiah MA, Al-Khasawneh A, Althunibat A. Exploring the critical challenges and factors influencing the E-learning system usage during COVID-19 pandemic. Education and Information Technologies. 2020 Nov;25:5261-80.*

3. *Mayasari LI, Kemal I. The role of teachers in implementing distance learning in the middle of the Covid-19 plague. Systematic Reviews in Pharmacy. 2020;11(12):1553-7.*
4. *Aboagye E, Yawson JA, Appiah KN. COVID-19 and E-learning: The challenges of students in tertiary institutions. Social Education Research. 2021:1-8.*
5. *Muilenburg LY, Berge ZL. Student barriers to online learning: A factor analytic study. Distance education. 2005 Jan 1;26(1):29-48.*
6. *San-Martнn S, Jimйnez N, Rodrнguez-Torrico P, Piceiro-Ibarra I. The determinants of teachers' continuance commitment to e-learning in higher education. Education and Information Technologies. 2020 Jul;25(4):3205-25.*
7. *Sшrebш AM, Sшrebш Ш. Understanding e-learning satisfaction in the context of university teachers. World Academy of Science, Engineering and Technology. 2008 Oct 22;46:72-5.*

Teachers satisfaction towards E–learning

Baljinnyam.B[1], Gal-Erdene.S[1], Uzmee.M[1], Naransukh.G[1], Khandmaa.S[1]
[1]Division for faculty development and e-learning, MNUMS
baljinnyam@mnums.edu.mn

ABSTRACT

During this discontinuation of classroom training due to COVID-19 pandemic situation and the organization of e-learning training, aimed to study how teachers are conducting their e-learning training, their satisfaction in e-learning and also how to implement e-learning in the future. Total of 342 teachers were involved in the study, and the information was collected through questionnaires, identified current situations, future possibilities and satisfaction and calculated the results. Most of the teachers conducted training using a combination of online face to face and web-based methods. The disadvantages would be time consuming for teachers, lack of student participation, limits of practicing procedures and skills, but being regardless of distance is definitely an advantage. In the future, it would be appropriate to combine classroom and e-learning training, and to conduct most of the lectures and self-study through e-learning, and in order to do these activities teachers need technological support. Teachers' satisfaction with their knowledge of e-learning, the environment, the comparison of e-learning with classroom training, teachers giving feedback to students, validity of assessment, and the learning system were average or above. Even though there are disadvantages in e-learning training, teachers are satisfied with e-learning and the use of blended learning is likely to increase in the future.